



УЛААНБААТАР

ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1979 оны 4 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 35

Улаанбаатар

Хотын АХ-ийн 1979 оны 126 д тогтоо

хот

АГНУУРЫН БРИГАД БАЙГУУЛАХ ТУХАН

БНМАУ-ын Засд нийн Бөвлөлийн 1979 оны 2-р сарын 19-ний
сдрийн 62-р тогтоолыг биелүүлэх зорилгоор Улаанбаатар хотын
АХ-ийн гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын ой, агнуурын ам ахуйн дэргэд аг-
нуурын бригадыг ам ахуйн тооцоотойгоор байгуулан амилдуул-
сугай.

2. Агнуурын бригадын дүнийг хөдөөмөлтөөр баталсугай.

3. Агнуурын бүтээгдүүн бэлтгэх төлөвлөгөөг боловсруулан
хотын гүйцэтгэх захиргааны төлөвлөгөөний комисст оруулах,
Бригадын зохион байгуулалт, орон тоо, цалин хэмжээний тэвч
боловсруулан ИХБХ Хорсо, ОМАУ Яаманд оруулан батлуулахыг
ой, агнуурын ам ахуй /н.Баттасүрэн/-д даалгасугай.

4. Агнуурын бригаданд ангийн үс, нэх, агнуурын таралтай
бүтээгдүүн бэлтгэх төлөвлөгөөг ний бүрийн төлөвлөгөөнд
тусган өгч ба хнг Хотын гүйцэтгэх захиргааны төлөвлөгөөний
комисс /н.Дугаржав/-т даалгасугай.

5. Бригадын агуулах, байр барих, гур байр байгуулах,
буу сум, зогсг хэрэглэл бэлтгэхэд богино хугацааны зээл
олгохыг хотын Банкны контор /н.Совд/-т даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ТОГТООЛ

УЛААНБААТАР ХОТЫН АХ-ийн ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦАГЧИЙН ТӨЛӨӨ
БРИГДЫН ДАРГА

С.БЭХЛАЛГАЛ
Ч.А.БАЛ

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1979 оны 65-р тогтоолоор батлав.

АГНУУРЫН БААЛГЫН БРИГАДЫН ДҮРЭМ

НЭГ. Агнуурын бригадын зохион байгуулалт

1. Анчдын бригадыг төрийн захиргааны дээд байгууллагын шийдвэрийг үндэслэн Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа байгуулна.

2. Агнуурын бригад нь Улаанбаатар хотын ой, агнуурын аж ахуйн дэргэд аж ахуйн тооцоон дээр ажиллана.

3. Бригад нь агнуурын хууль тогтоомжийг хэлбэрэлтгүй биелүүлж, хотоос агнуурын гаралтай түүхий эд бэлтгэж улсад нийлүүлэх төлөвлөгөөт дэглэврыг хугацаанд нь чамартай биелүүлэх, ойн сусад дэгалт баялагийг ашиглах ан амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх ажилд анчдын нийгэмлэгийн гишүүдийг татан оролцуулахад оршино.

4. Агнуурын бригадын жилийн үйлдвэрлэлийн ажлын төлөвлөгөө, ан амьтныг өсгөн үржүүлэх, тогтвортой байршуулахад зорхулагдсан арга хэмжээний дэглэврыг Монголын анчдын нийгэмлэгийн төв зөвлөлийн саналыг харгалзан хотын ой, агнуурын аж ахуйгаас боловсруулж Улаанбаатар хотын Төлөвлөгөөний комиссоос батлана.

5. Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас томилогдсон дарга, агнуурын бригадыг өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэж, хотын ой, агнуурын аж ахуй төвлөрсөн удирдлагээр хянана.

6. Агнуурын бригадын үйлдвэрлэл, хөдөлмөр зохион байгуулалт материал хангамжийн асуудлыг Хотын ой, агнуурын аж ахуйн уламжилснаар Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, Монголын анчдын нийгэмлэгийн төв зөвлөлөөс шийдвэрлэнэ.

ХОЁР. Агнуурын бригадын эрх, үүрэг

1. Агнуурын бригад нь дор дурьдсан эрх эдэлнэ.

а/ Анчдын бригад нь ан агнуурын эдэлбэр газартай байна.

б/ Агнуурын эдэлбэр газартаа агнуурын зориулалттай төрөл бүрийн бэлтгэх, агуулах, түр сууд барьж ашиглах.

в/ Агнуурын бригадын гишүүд зохих хууль тогтоомжоор ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслэлээр хангагдах;

г/ Хууль тогтоомжид заагдсан цалин хөлс, амралтыг эдлэх.

д/ Ангийн буу, зэвсэг, сум хэрэглэлийг улсаас нэгдсэн журмаар авч ан агнуурын хууль тогтоомжийн дагуу эзэмших;

е/ Бригадын үйлдвэрлэлд тээврийн хэрэгслэлээр үйлчлүүлэх;

ё/ Ангийн үсний экспортын болон төлөвлөгөөт даалгаврыг давуулан биелүүлсний шагнал урамшил авах;

ж/ Гадаадын анчин, жуулчдад үйлчилсний хураамжийн орлогыг нийгэмлэгийн дансанд шилжүүлэх;

з/ Ан амьтны баялгийг хамгаалах, өсгөн үржүүлэх, зөв зохистой ашиглах, агнуурын аж ахуйг боловсронгуй болгож хөгжүүлэх санал тавих;

2. Агнуурын бригад нь дор дурьдсан үүрэг гүйцэтгэнэ.

а/ Хотын агнуурын төлөвлөгөөт түүхий эдийг бэлтгэж улсад нийлүүлэх, спорт-агнуурын зориулалтаар ан агнахдаа байгаль хамгаалах болон ан агнуурын хууль тогтоомжийг биелүүлэх, түүхий эдийн чанарыг сайжруулах;

б/ Анчдын нийгэмлэгийн гишүүд, олон нийтийн хүч тусалцаанд түшиглэн ан агнуурын хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг зохион сайжруулах;

в/ Байгаль орчноо хамгаалах, ан амьтны ноогийг арвижуулах арга хэмжээнд оролцох;

г/ Бригадын анчдын агнуур зүйн мэдлэг, ан агнах дадлага, арга барилыг дээшлүүлэх ажил зохиох;

д/ Агнуурын бүх бүтээгдэхүүнийг ан агналт явуулсан орон нутгийн худалдаа бэлтгэлийн байгууллагад тогтоогдсон зэрэг дугаарын үнийн дагуу түшээх.

е/ Байгаль хамгаалах хууль тогтоомжийг хөдөлмөрчдөд сурталчлахын хамт өөрийн орны болон социалист орнуудын анчдын туршлагыг ажилдаа нэвтрүүлэх.

ГУРАВ. Агнуурын бригадын хөрөнгө, тайлан
тооцоо

1. Үйлдвэрийн ажиллагааг жигд явуулахад шаардагдах үйлчилгээ, тээвэрлэлт, аж ахуйн зориулалт бүхий үндсэн фондтой байна.

2. Бригадын үйлдвэрлэл, санхүү материалын тайлан нь Монголын анчдын нийгэмлэгийн төв зөвлөлийн балансад тусгагдана.

3. Бригадын үйл ажиллагаатай холбогдсон санхүүжилтыг хотын банкны контороос богино хугацааны зээлээр зохицуулана.

4. Бригадын эд хөрөнгийг хүн бүрт карт хөтлөж хариуцуулна.